

## МОНГОЛЫН АНУ СУДЛАЛЫН ТӨВИЙН АНХДУГААР ХУРАЛ

1991 оны 1-р сарын 23-нд БНМАУ-ын ШУА-ийн Дорнодахины судлалын хүрээлэнгийн хэсэг эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтан нар санаачлан Монголын Америк судлалын Төв байгуулж, уг төвд элсэх гишүүдийг бүртгэх зарлал «Ардын эрх» сонинд гаргасан билээ. Түүнээс хойш төвд гишүүнээр 40 шахам байгууллагын 80 гаруй, үндсэндээ судалгааны ажилтан бүртгүүлэв. Энэ оны 2-р сарын 9-нд төвийн гишүүдийн анхдугаар зохион байгуулах хурал болж, төвийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, дүрмийг хэлэлцэж батлав. Төвийн гишүүдийн анхдугаар хурал 1-р сарын 23-нд санаачлагчдын хэсгийн хийсэн зохион байгуулалтыг өөрчилж, төвийн нэрийг «Монголын АНУ судлалын Төв» хэмээн нэрлэхээр тогтов. Төвийн тэргүүлэгч гишүүнээр 9 хүнийг, төвийн тэргүүнээр ШУА-ийн гишүүн, доктор профессор Н. Ишжамцыг, төвийн зохицуулах нарийн бичгийн даргаар дэд эрдэмтэн С. Ишдоржийг сонгов.

Төвийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг доорхи байдлаар тогтов. Үүнд:

— АНУ судлалыг манай оронд хөгжүүлэх эх суурийг тавьж, монгол-америкийн ард түмний харилцан ойлголцох, итгэлцэх явдлыг бэхжүүлэх, тэдгээрийн хамтын ажиллагааг өргөтгөн хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах;

— БНМАУ, АНУ-ын хооронд хамтын ажиллагаа эхлэж, манай улс зах зээлийн эдийн засагт шилжих гэж байгаатай уялдуулан АНУ ын гадаад, дотоод бодлогын зарим асуудал, шинжлэх ухаан-техник, эдийн засаг, боловсрол, соёл урлаг, үйлчилгээний эсрэг салбарт суурь болон хавсрага судалгааг бололцооны хэрээр хийж, хоёр орны хамтын ажиллагааны тодорхой чиглэлийг нарийн тогтоож, боловсронгуй болгон хэрэгжүүлэхэд тус дэм үзүүлэх;

— АНУ-ын эдийн засаг, шинжлэх ухаан-техник, технологи, боловсрол, соёл урлаг, эрүүлийг хамгаалах, үйлчилгээ болон бусад салбар дахь ололтыг судалсны үндсэн дээр тэдгээрээс Монгол орны нөхцөлд бүтээлчээр хэрэглэж болох зүйлсийг эрэлхийлэх;

— Төвийн гишүүд, манай хүмүүсийн мэргэжлийн болон англи хэлний мэдлэг боловсролыг дээшлүүлэх талаар бололцоотой бүхнийг хийх;

— Манай орны судалгааны байгууллага, хамтлаг, эрдэмтэд, хувь хүмүүсээс АНУ-ын ижил төрлийн байгууллага, хамтлаг, эрдэмтэд, хувь хүмүүстэй ажил төрлийн хэлхээ холбоо тогтоон хамтран ажиллахыг хөхүүлэн дэмжих зэрэг болно.

Төвийн гишүүдийн хурлаас төвийн харьяа тодорхой салбаруудыг байгуулах, цаашдаа өөрийн тогтмол хэвлэлтэй болох зэрэг зохион байгуулалтын асуудлыг даруйхан шийдвэрлэж, энэ оны эцэс гэхэд зохион байгуулалтын хэлбэртээ бүрэн орсон байхыг Төвийн тэргүүлэгч гишүүдэд үүрэг болгов.